

Эрдэм шинжилгээний өгүүлэл
УДК 24(09)(517.3)
DOI 10.18101/2949-1657-2026-1-79-84

Бурханы шашны сэтгэл зүй монголчуудад уламжлагдсан нь

© **Отгонбаяр Цэрэнбат**
гавж доктор, профессор
МБШТ Гандан хийд
Gandantemple@yahoo.com

Хураангуй. Бурханы шашны сэтгэл зүйн Авидхарма болон Калачакрагийн номлолыг орчин үеийн шинжлэх ухааны онолтой харьцуулан авч үзэхийг оролдсон нийтлэл болно.

Түлхүүр үг: Бурхан шашин, Авидхарма, Калачакра, сэтгэл зүй.

Ишлэл

Отгонбаяр Цэрэнбат. Бурханы шашны сэтгэл зүй монголчуудад уламжлагдсан нь // Зүүн зүгийн вектор: түүх, нийгэм, улс. 2026; 1: (Орос хэл дээр). Х. 79–84.

Бурханы шашны сэтгэл зүй монголчуудад уламжлагдсан нь Бурханы шашинт монголчууд болон бүтэц хүрээлэн буй орчинтойгоо зохицох есон хэмээн том агуулгыг товчлон хамруулав.

Монголд бурханы номлол энэтхэг хятад түвдээр дамжин гурвантаа дэлгэрснийг өөрсдийн онцлогт тулгуурлан нутагшуулсан байдаг. Бурханы номлол нь янагш болон ил чанагш болон далд хоер үнэн дээр тулгуурлан

1. Уур хилэнгүй эгэл хэвийн аав ээж үр хүүхдийн үүрэг хүлээн амьдрах

2. Бусдыг байгаагаар нь хүлээн зөвшөөрч чаддаг чадвар суух.

3. Өөрийн сэтгэлээ номхтгож чаддаг /архи тамхи эсэн бусын үйлийг тэвчих / хүмүүнийг ес зүй сахисан бурханы шашинтан монгол хүмүүн гэж нэрийдсээр иржээ.

Бид агаарт эргэлдэж байгаа бөмбөрцөг дэлхий дээр амьдардаг хэн хэзээ бүтээсэн яагаад эргэлдэж байгаа талаар одоохондоо нотолсон зүйл үгүй таамаг төдий.

Энэ талаархи шашины зарим нэг номлолыг материлист үзэлтэнгүүд худал мухар сүсэг гэж хэлэхээс бус ингээд буруу гэдгийг нь шинжлэх ухаанаар нотолсон зүйл бас байхгүй. Эволюцийн онолын эцэг гэгдэх Чарльз Дарвин гэх эрдэмтэн хүн сармагчнаас үүссэн гэх онолыг барьсаар олон жил өнгөрлөө нэг ч сармагчин хүн болсонгүй. Тэгвэл Германы эрдэмтэн Альберт Энштэйны хэлснээр хамгийн шинжлэх ухаанч шашныг буддизм гэдэг ба үүнийг нь судлаад үзэх нь алс ирээдүйн гаргалгаа болох магадлагаатай гэж хэлсэн үзэл бодлын үүднээс энэхүү илтгэлийг тавьж байна.

Бурхан будда энэхүү орчлонгийн системийг хүмүүст ойлгуулахын тухайд орчлонгийн хүрд хэмээх зураглал зохиосныг товч танилцуулбал орчлон эхлэл төгсгөлгүй учир бөөрөнхий хэлбэрээр дүрсэлсэн.

Уг зургийн голд 1. гахай — мунхаг

2. Могой-уур

3. тахиагаар зүйрлэн авч хамаг муу бүгдийг үүсгэгч хэмээн үзэж муу бүгдийг үүсгэгч хэмээн үзэж энэ гурваас сэргийлж чадваас дараагийн цагирагт орж нар зөв эргэлтийн цагирагт орж нар зөв эргэлтийн дагуу өгсөн сайжирч буйг цагаан дэвсгэр дээр харуулан, хүмүүн, асар тэнгэр, урт наст тэнгэр гэх сайн заяанд төрж буйг үзүүлдэд эс сэргийлбээс хар дэвсгэр дээр уруудан зурж дараагийн цагираг доторхи там бирд адгуус гэх муу заяанд төрдгийг дүрслэн зуржээ.



Гадна хүрдэнд эдгээр 6 төрөл нь сансар нирваанд хэрхэн эргэлдэх есыг 12 дүрсээр зурж харуулжээ.

1. Таяг тулсан сохор хүнээр зүйрлэсэн нь мунхагаар явбал энэ мэтийг сануулжээ.
2. Хуран үйлдэгч шавар зэрэг зүйлийг цуглуулан ваар хийж буй хүнээр дүрсэлсэн нь хэрэгтэй хэрэггүй юмыг цуглуулж буйг харуулсан /өөрт хэрэггүй эд эдлэл цуглуулсаар хураасаар байдаг/
3. Тийн мэдэх сармагчин модноос жимс авч буйгаар дүрсэлсэн нь өөрт оногдсон хувь заяагаар тохиож буйг харуулсан

4. Нэр дүрс үүгээр бие ба сэтгэлийг бүрдүүлэгч 5 цогц буй болохыг харуулсан.

5. Төрөн түгэхүй хэмээхийг хоосон байшингаар дүрсэлсэн үүгээр боломж чинийх байхыг харуулсан.

6. Хүртэхүй үүгээр эр эм 2 хурьцал хийж буйгаар дүрсэлсэн энэ нь нүд чих хамар ам гэх мэт мэдрэхүйн ухаан төрж буйг харуулжээ.

7. Амсуурга буюу мэдрэхүй үүгээр нүдэндээ сум зоосон хүнээр дүрслэн зовлон жаргалыг мэдэрч мунхараад сохор болсон мэтийг дүрсэлсэн.

8. Шунахай үүгээр орчлонгийн алив зүйлд шунахыг харуулж байна.

9. Авахуй үүгээр зөвхөн авахын дон шүгэлж үхсэн ч хамаагүй гэх нэгнийг дүрсэлжээ.

10. Болохуй үүгээр сайн муу үйл бүгдийг хурааж үйлээ эдлэх ес гүйцснийг харуулжээ.

11. Төрөхүй үүгээр үйл гүйцээд төрөх оронд заяагдснийг харуулжээ.

12. Өглөх үхэхүй үүгээр хүүр дүүрч яваа хүмүүнийг дүрсэлжээ.

Дээрх 12 шүтэн барилдлага нь хүмүүний нэг удаагийн амьдралд тохиох боломжгүй боловч хоер юмуу түүнээс дээш төрөл тутамд давтагддаг циклтэй...

Энэхүү хүрдний гадна хэсэгт хүрдийг атгаж зуурсан матраар үхлийн эзнийг дүрсэлж хэн ч тойрч гарахгүйг сануулсан байдаг

Энэ хүрднээс гарах арга ухааныг зүүн дээр зогсож буй бурхан багш зааж буйгаар дүрсэлжээ. Энэхүү тайлбарыг Монгол лам Ишжанцан бээр ингэж тайлбарлажээ.

Ерөнхийдөө гадаад сав орчлонгийн тогтолцоо иймэрхүү байдаг гэдгийг дүрсэлсэн буддын тайлбар номлол байдаг. Одоо шимийн амьтаны тогтолцоог харуулбал сар болон бусад гариг эрхэсийг шинжлэхдээ сарны дээж авч үздэгтэй адил сав орчлонг шинжлэхдээ шимийн амьтан хүнийг нарийн судлах хэрэгтэй. Бурханы шашинтан монголчууд хүмүүний гадаад болон дотоод бүтэц хүрээлэн буй орчинтойгоо зохицох зохицолын талаар дурдвал

А. Гадаад бүтэц.

Бид аура буюу гэрлэн бүрхэвч гэж ярьдаг ба түүнийг хэмждэг багаж хүртэл байдаг аура ихтэй хүнийг сайн гэж ярьцгаадаг тэгвэл үүнийг бурханы шашинт монголчууд заяаны таван тэнгэр хэмээх бурханаар тайлбарладаг сайн яваа нэгнээ заяа нь хаясан гэж ярьцгаадаг.

Ийнхүү заяаны таван тэнгэр нь эхээс мэндэлхэд хамт төрдөг түүнийг задалбал

1. Сүлдэн тэнгэр энэ нь арван учрал найман чөлөө бүрдсэн сүнслэг бие сайн үйлийн үрээр дүрсгүй орчлонгоос дүрст орчлонд орох явцыг хэлнэ.

2. Орны тэнгэр энэ нь дүрсгүй орчлонгоос дүрст орчлонд шилжихдээ зохих үйлийн үр заяа төөргөөр зохих үйлийн үр заяа төөргөөр 360 гариг ертөнцийн нэгийг сонгодог түүнийг төрсөн нутаг гэдэг энэ нь орны тэнгэр болно.

3. Нөхрийн тэнгэр энэ нь төрөх нутаг заяагдсаны дараа ээж аав 2-ын хүслээс эхийн хэвлийд үр тогтох буюу хилэнт арван тэнгэр дагуул арван охин тэнгэр дагуул арван охин тэнгэртэй умайд оршдог үүнийг анагаах ухаанаар хромсом гэдэг ба хамгийн түрүүнд эерэгээр хүлээн авсан эжий аав хоер нөхрийн дээд тэнгэр болно. Иймээс сонголтгүй заяагдсан нутагаа муулах ээж ааваа хүндлэхгүй бол заяаны таван тэнгэр нь атаат таван тэнгэр болдог гэдэг.

4. Эдийн тэнгэр энэ нь сүлдтэй хамтран хүний биеийн доторхи венийн судсаар шинийн 1-30 хүртэл доошлон нууцын орон буюу бэлэг эрхтэнд оршдог.Энгийн жишээгээр яривал хүдэр гэдэг амьтаны заар буюу төмсгийг том болохоор нь авах гэж шинийн 15-ныг хүлээж байгаад алдаг яагаад гэвэл 15-нд томордог ба том нь их үнэтэй тул анчид ингэж ашиг олдог нь бодит жишээ юм. Шинийн 15-25 хүртэл артер судсаар дээшилдэг ба голдуу суга цавинд байрладаг ийм үед суга цавиа сайн цэвэрлэж бай гэж ээж аав захидаг байсан. Эс цэвэрлэвээс эд эдлэл доройтох гарз гарах шалтгаан болдог гэж үздэг.

5. Хийморийн тэнгэр: Энэхүү тэнгэр нь хүний баруун зүүн 2 мөрөнд байрладаг. Баруун мөрний тэнгэр хүслээр явах дуртай, зүүн мөрний тэнгэр эргэцүүлэн бодох чадвартай учир эзэнд сайн муу 2 дохио өгдөг. Эзэн үүнийг шийддэг.

Хүний биеийн бүтэц нь 2 хөлтэй 2 гартай 2 чихтэй 2 нүдтэй тэгш хэмтэй. Хүмүүн адгууслаг талруугаа явах уу хүмүүнлэг талдаа байх уу гэдгийн уураг тархи шийддэг.

Энэхүү таван тэнгэр доройтвоос хийморь сүлд доройтож аура

Б. Хүмүүний дотоод бүтэц.

Анагаах ухаан хүний биеийн дотоод бүтцийг элэг, дэлүү, бөөр, зүрх, уушиг хэмээх 5 цул эрхтэн цөс, гэдэс, ходоод олгой, давсаг самс буюу эрийн хушга эмийн өндгөвч гэж 5 цул эрхтэн 6 сав эрхтэн гэж тайлбарладаг.

Миний бодлоор хүн гэдэг нь дэлхий галактикийн жижиг хэсэг гэж үздэг ба Дэлхийн 5 тивийг төлөөлж 5 цул эрхтэн, 6 далайг төлөөлж 6 сав эрхтэний бэлэгдэлтэй гэж монголчууд ярьдгийг дурдах нь зүйтэй.

Бурханы сургаалд сүлдэн тэнгэр эхийн умайд оршихоос өмнө үйлийн үрээр аль нэг ядам бурханы хөрөнгө 7 чакра буюу хүрд үүсэж эхийн умайд ормогц эрхтэний системийг үүсгэдэг гэж үздэг.

Жишээлбэл Калачакра бурханы, ХАМ ЧА, МА, ЛА, БА, РА, ЯМ гэх үр хөрөнгө үсэг хамт орж орой, магнай, хоолой, цээж, зүрх хүйс, нууцын орон зэргийг үүсгэдэг ба түүн дээр УМ-АА ХУМ гурван хөрөнгө үсэг нэмэгдэж УМ хөрөнгөөр бусдаас ялгаж АА хөрөнгөөр цэвэрлэж, ХУМ хөрөнгөөр ариутгадаг ба ингэснээр УМ-АА-ХУМ-Ч-МА –ЛА –БА –РА –ЯМ хэмээх арван хөрөнгө төгөлдөржиж хос хорин хромсом болон зөвхөн эрдэмтэн хүний биеийг олдог хэмээжээ.

-МА –ЛА –БА –РА –ЯМ хэмээх арван хөрөнгө төгөлдөржиж хос хорин хромсом болон зөвхөн эрдэмтэн хүний биеийг олдог хэмээжээ.

Амьтан адгуусанд энэ шинж илэрдэггүй.

Хүний 5 цул 6 сав эрхтэн буй болоод түүний дараа удирдлагын баг болох 5 цогцыг Бурхан багш билгийн зүрхэн судартаа заахдаа 1.Дүрс 2.Мэдрэхүй 3.Хуран мэдрэхүй 4.Хуран үйлдэхүй 5.Унаа буюу сүлдэн тэнгэр гэж 5 цогцыг нэрлэжээ.

Хүн үхэхдээ бие буюу дүрсээ хаяаад сүлд гэдэг унаандаа суугаад 4 цогцос болоод явдаг ирдэг гэжээ.

Үүнийг орчин үеийн эрдэмтэд болох Германы эрдэмтэн Зигмунд Фрейд, Швейцарын эрдэмтэн Карл Юнг, Америкийн эрдэмтэн Ричард Шварц нар хүлээн зөвшөөрч цааш нь дэлгэрүүлэн тайлбарласан байдаг.

Отгонбаяр Цэрэнбат. Бурханы шашны сэтгэл зүй монголчуудад уламжлагдсан нь

№	Бурхан багшийн тайлбар (Таван скандха)	Орчин үеийн эрдэмтдийн ойлголт
1	Дүрс (Рупа)	Боди (Бие махбод, физик бүтэц)
2	Мэдрэхүй (Ведана)	Его
3	Хуран мэдэхүй (Самжня)	Далд ухамсар
4	Хуран үйлдэхүй (Самскара)	Далд ухамсар
5	Сүлд (Вижняна)	Ухамсар

Сүлд дээрхи хүснэгтээс харвал дүрс сүлд хоерыг шууд утгаар нь хүлээн зөвшөөрч хүн сүнс сүлдтэй гэдгийг шинжлэх ухаанд нотлон харуулжээ.

Тэдгээр эрдэмтдийн баг 2 дугаарт байх, мэдрэхүй хэмээх цогцсыг эго буюу хүний халуун хүйтнийг мэдэрдэг мэдрэмж хэмээн томъёолсон бол

3 дугаарт бичигдсэн хуран үйлдэхүйн цогцсоор далд ухамсар буюу хажуугаас нөлөөлөх нөлөөлөл хөгжим сонсох, ном унших, сонирхолтой бүжиг, жүжиг харах, бөө онго шүтээнийг онцгой гэж үзэх зэргээс хам шинж нөлөөлдөг гэж үздэг байна.

4 дүгээрт бичигдсэн хуран үйлдэхүйн цогцсыг далд ухамсар гээд зүүд нойроор дамжин далд орчлонд орох үүдийг нээх гэж тайлбарлажээ.

В. Хүрээлэн буй орчинтойгоо зохицох есон.

Монголчууд гадна байгалиа амьтай гэж үзэж юу олдсоныхоо дээдийг бурхандаа өргөж гадаад 5 тэнгэр болох заяаны таван тэнгэртээ залбирдаг, Юу идсэнийхээ дээдийг уул ус лус савдагтаа өргөдөг үүгээр дотоод таван цогцосдоо тахил өргөж байна гэж үздэг. Мөн таньдаа баярлалаа хэмээн талархдаг, даатгадаг, уул усаа дархалдаг цаашлаад цалин пүнлүү өгдөг есон одоо болтол буй.

Гишгэж байгаа газраа гэмтээхгүй гэж гутлын хоншоорыг дээш нь болгож ээтийлгэдэг ес зүйтэй ард түмэн.

Монголын нууц товчоо хэмээх сударт Онон Мөрөн тэргүүтэй ус голдоо үнэнээ очин даатган байж дайнд морддог жишээ олон буй. Бурханы айлдсан судрын хураангуй номонд замбуулинд ус хаана байна тэнд амьд лус байна тэр нь орчлонгийн нүд хэмээн үзэж усанд дүрсээ харуулж хүслээ хэл хэмээн айлджээ.

Мөн орчин үеийн Японы эрдэмтдийн баг усыг шинжлээд хараал хэлээд хөлдөөвөл муухай дүрс мөс болж буйг нотлон шинжлэх ухааны аргаар усыг амьтай гэдгийг тогтоосон байдаг.

Тиймээс бид гадаад орчинтойгоо нэгэн цул болохыг үзүүлэх 2 жишээ хэлбэл

1. Агаарт нисэх бүргэд хэмээх шувуу биднээс олон дахин бага нүдтэй боловч 10 км-ээс хол зайд буй хулгана зурмыг шууд харах нүд, хөдөлгөөн сонсох, үнэртэх, мэдрэх чадварууд байдаг. Энэ нь бүргэдэд агаар нь томруулагч линз, сонсох үнэрлэх мэдрэх аппарат мэт бүргэдийн нэг эрхтэн мэт болжээ.

2. Усанд буй загас бас л олон км алсад буй зүйлийг харах сонсох үнэрлэх эрхтнүүдээрээ мэдэрдэг яагаад гэвэл ус түүний нэг дамжуулагч эрхтэн болж өгдөгт оршино.

Тэгвэл хүн агаарт нисэх бүргэд усанд байх загас мэт гадаад орчинтойгоо зохицох хэрэгтэй. Тиймээс бидний төрсөн нутаг эх дэлхий маань бидний нүдний цөцгий мэт хайрлан хамгаалах объект гэж айлдан бурхан Буддагийн сургаалиар илтгэлээ өндөрлөе.

Статья поступила в редакцию 16.02.2026; одобрена после рецензирования 27.02.2026; принята к публикации 02.04.2026.

The Transmission of Buddhist Psychology to the Mongols

Tserenbat Otgonbayar

Gavju Doctor, Professor

Gandantegchinlen Monastery (Center of Mongolian Buddhists)

Gandantemple@yahoo.com

Abstract. The article attempts to examine and compare the Buddhist psychological doctrines of the Abhidharma and Kalacharka with modern scientific theories.

Keywords: Buddhism, Abhidharma, Kalacharka, psychology.

For citation

Tserenbat Otgonbayar. The Transmission of Buddhist Psychology to the Mongols. *Oriental Vector: History, Society, State*. 2026; 1: 79–84 (In Mong.)

The article was submitted 16.02.2026; approved after review 27.02.2026; accepted for publication 02.04.2026.